

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГ ДАХЬ ИРГЭНИЙ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД АНХААРАХ АСУУДАЛ

О.Цадмэдший

Хууль сахиулахын их сургуулийн магистрант

Хууль зүйн яам, Цагдаагийн ерөнхий газар, Нээлттэй нийгэм форум цагдаагийн байгууллагын эрх зүйн орчныг сайжруулах, батлагдсан хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжилтийг зохион байгуулах чиглэлээр 2013 оноос эхлэн хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж эхэлжээ. Энэ ажлын хүрээнд Нээлттэй нийгэм форумаас 2014 оны 5 дугаар сард “Иргэний зөвлөлийн дүрэм”, “Иргэний зөвлөл, оршин суугчдад Цагдаагийн байгууллагын тайлан тавих журам”-ын төслийг сайжруулан боловсруулах, хэлэлцүүлэг зохион байгуулах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, гарын авлага боловсруулах ажлыг гүйцэтгэх зөвлөх сонгох шалгаруулж гүйцэтгэжээ.

Дүрэм, журмын төслийг сайжруулах хүрээнд ХСИС-ийн мэргэжлийн багш нар, магистрант, докторант, Цагдаагийн алба хаагч, Олон нийтийн байцаагч, нийслэл, дүүргийн ИТХ-ын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ажилтнууд, Иргэний нийгэм, төрийн бус байгууллагын төлөөллийн дунд 5 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулж, гарсан санал, шүүмжлэлийг авч ажилласан байдаг. Түүнчлэн, орон нутгийн цагдаагийн алба хаагч, гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх ажил хариуцсан ажилтан, олон нийтийн байцаагч, иргэдийн санал, шүүмжлэлийг авждүрмийн төслийг боловсруулахад гадаад, дотоодын адил төстэй чиг үүрэг бүхий зөвлөлийн туршлагыг судалж ашиглажээ. Үүнд Япон, Канад улс, ОХУ, АНУ-ын Луйзана муж болон Интерполд нэгдэн орсон зарим гишүүн орны цагдаагийн байгууллагын хууль, иргэний зөвлөлтэй адил чиг үүрэг бүхий хороо, зөвлөлийн бүтэц, дүрэм, АТГ-ын дэргэдэх Олон нийтийн зөвлөлийн ажиллах журам зэрэг хамаарна. Хууль зүйн сайдын 2014 оны А/89 дугаар тушаалаар “Иргэний зөвлөлийн дүрэм”, “Иргэний зөвлөл, оршин суугчдад цагдаагийн байгууллагын тайлан тавих журам” батлагдаж, аймаг, нийслэлд иргэний зөвлөл байгуулагдаж, үйл ажиллагаагаа явуулж байна. ЦЕГ-ын даргын 2014 оны 09 дүгээр сарын 26-н өдрийн 597 дүгээр тушаалаар “Иргэний зөвлөлийн гишүүний сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө¹” батлагдаж, улмаар ЦЕГ-ын Хэвлэх үйлдвэрт “Иргэний зөвлөлийн гишүүний гарын авлага”² хэвлэгдэн гарсан байна.

Цагдаагийн байгууллагын тухай хууль 1994 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш 20 жил өнгөрлөө. Өнгөрсөн хугацаанд манай улсын эдийн засаг, нийгмийн бүхий л харилцаанд ихээхэн өөрчлөлт орж, энэ хурдацтай өөрчлөлттэй үйл ажиллагаагаа нийцүүлэх шаардлага бий болсон. ШУА-ын Философи, социологи, эрх зүйн хүрээлэн, Азийн сан, Олон улсын Монгол соёлын төв, Максима судалгааны төв, ХСИС-ийн Цагдаа судлалын төв зэрэг байгууллагын хийсэн судалгаа цагдаагийн байгууллагад тогтолцооны болон үйл ажиллагаа, удирдлагын зарчмын шинэчлэл хийх шаардлагатай болохыг дурьдсанбайдаг³.

¹Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө нь Иргэний зөвлөлийн гишүүнээр ажиллах иргэнд ЦБ-ын үйл ажиллагаа, эрх зүйн зохицуулалтын талаар мэдээлэл өгөх, хуулиар хүлээсэн эрх, үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны арга, хэлбэрийн талаар харилцан мэдээлэлөгч, санал солилцох, нэг мөр ойлголттой болоход чиглэгдсэн юм.

²Энэхүү гарын авлагад иргэний зөвлөлийн эрх зүйн зохицуулалт, үйл ажиллагааны талаар оруулсанаас гадна ЦБ-ын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих үүргээ хэрэгжүүлэхэд хэрэгцээтэй хууль, тогтоомж, хөтөлбөр, төлөвлөгөө, танилцуулга, мэдээлэл, статистик, тайлан зэргийг оруулсан нь зөвлөлийн гишүүнд мэдээлэл өгч, үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд дэмтэй гэж үзсэн.

³<http://www.police.gov.mn/news/content/id/204/type/33>

Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт цагдаагийн хэв журам сахиулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийг орон нутгийн эрх мэдлийн түвшинд зохион байгуулах, төрийн байгууллага, албан хаагчийн эрх, үүргийг боловсронгуй болгож иргэддээ үйлчилдэг, ил тод, нээлттэй байх зарчмыг хэрэгжүүлэхээр заасан. МУ-ын Ерөнхийлөгчийн Тамгын газраас 2012 оны 04 дүгээр сард Цагдаагийн алба, алба хаагчийн эрх зүйн байдал, үйл ажиллагааны тухай хуулийн төслийг боловсруулах Ажлын хэсэг байгуулагдан ажилласан.

Засгийн газраас хууль зүйн салбарын шинэтгэлийн хүрээнд боловсруулсан зарим хуулийн төслийг өргөн барьсныг УИХ хэлэлцэн 2013 оны 7 дугаар сарын 5-ны өдөр “Цагдаагийн албаны тухай хууль”-ийг батлан, мөрдөгдөж эхэлсэн.

Цагдаагийн байгууллагын олон нийтэд түшиглэсэн үйл ажиллагаа, олон нийтийн цагдаагийн ажилтны эрх, үүрэг, цагдаагийн байгууллагын ухаалаг буюу иргэнд ойрхон бүтэц зэрэг асуудлыгшийдвэрлэх учиртай.

1705 оноос баруун Европт *Police science* буюу цагдаа судлалын ухааныг үүсгэн, орчин үеийн цагдаагийн ойлголтын талаар судалж, хөгжүүлж ирэхдээ цагдаагийн албаны хөгжилд чухал хоёр зүйл бол:

- нэгдүгээрт *democratic control* буюу иргэний хяналт,
- хоёрдугаарт *political neutrality* буюу улс төрөөс ангид байх явдал гэж үзсэн байдаг.

Цагдаагийн албаны үйл ажиллагааг иргэний хяналтад оруулж, тэдний өмнө хариуцлага хүлээдэг болгохын тулд иргэний хяналт байдаг.

Цагдаагийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлд Иргэний зөвлөлтэй байхаар тусгасан. Энэ нь тус хуульд заасан “хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, ил тод, нээлттэй байх, олон нийтийн итгэлийг хүлээж, иргэний дэмжлэгийг авах” үйл ажиллагааны зарчмыг хэрэгжүүлэх чухал механизм мөн.

Цагдаагийн албаны тухай хуульд цагдаагийн албаны үйл ажиллагааны зарчмыг “иргэний дэмжлэгийг авах, төрийн болон төрийн бус байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага, иргэдтэй харилцан хамтран ажиллах” гэж тодорхойлсонтой уялдаж байна.

Цагдаагийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.10-д: “Иргэний зөвлөлийн дүрмийг энэ хууль, бусад хууль тогтоомжид нийцүүлэн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж заасны дагуу ХЗСайдын 2014 оны А/89 дугаар тушаалаар “Иргэний зөвлөлийн дүрэм”, “Иргэний зөвлөл, оршин суугчдад цагдаагийн байгууллагын тайлан тавих журам” баталсан.

Цагдаагийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлд “*Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих үүрэг бүхий 5-7 иргэний төлөөлөөс бүрдсэн орон тооны бус Иргэний зөвлөл аймаг, нийслэлийн ИТХ-ын дэргэд байна*” гэж заасны дагуу аймаг, нийслэлийн Иргэний зөвлөл байгуулж байна. Дүүрэгт Иргэний зөвлөл байгуулах асуудлыг цаашид авч үзэх зайлшгүй шаардлагатай.

Гадаадын зарим улсын туршлага:

Канад Улсын Цагдаагийн байгууллагын хөндлөнгийн хяналтын хороо: Канадын цагдаагийн байгууллагын хөндлөнгийн хяналтын хороог байгуулан ажилладаг бөгөөд хороо дарга, дэд даргаас гадна гурван гишүүнтэй байна. Гурван гишүүнийг Засгийн газраас томилно. Хорооны дарга байнгын гишүүн байх бөгөөд бусад гишүүдийг байнгын болон түр хугацааны гишүүнээр томилж болдог. Гишүүдийг таван жилийн хугацаатай томилох бөгөөд шаардлагатай тохиолдолд Засгийн газар хугацаанаас нь өмнө чөлөөлж болно. Томилгооны хугацаа дууссаны дараа гишүүнийг дахин томилж болно. Цагдаагийн байгууллагын алба хаагч хорооны гишүүн байхыг хориглоно. Хорооны байнгын болон түр хугацааны

гишүүдийн цалинг тэдгээрийн гүйцэтгэх ажилтай холбогдуулан Засгийн газраас тогтооно. Хорооны байнгын гишүүдийг “нийтийн алба хааж байна” гэж үздэг. Хорооны дарга эзгүй, үүргээ биелүүлэх боломжгүй байгаа тохиолдолд Сайд хорооны дэд даргыг үүрэг гүйцэтгэгчээр томилж болно. Хорооны дарга санхүүгийн жил өндөрлөснөөс хойш 3 сарын дотор тухайн жилийн хорооны үйл ажиллагаа, зөвлөмж бүхий жилийн тайланг Сайдад хүргүүлэх бөгөөд Сайд тайлангийн хувийг Парламентын хоёр танхимд чуулган эхэлснээс хойш 15 хоногийн дотор өгнө.

Канад Улсын Ванкувер хотын Цагдаагийн иргэний зөвлөл: Канад улсын Ванкуверт Цагдаагийн зөвлөл ажилладаг. Цагдаагийн иргэний зөвлөлийн даргаар Ванкуйверын хотын дарга ажилладаг ба нэг гишүүнээр нь Ванкуйвер хотын захиргааны нэг гишүүн томилогдох бөгөөд бусад 5 гишүүд нь орон нутгаас томилогддог байна. Ванкуйверын Цагдаагийн зөвлөл нь Цагдаагийн тухай хуульд зааснаар хараат бус, бие даасан, бүрэн эрхийн дагуу үйл ажиллагаа явуулдаг. Цагдаагийн зөвлөл нь хотын захиргаатай онцгой харилцан хамааралтай байдаг бөгөөд улс төрийн шийдвэр гаргах үйл явцаас цагдаагийн газрын бүрэн тусгаарлан ажилладаг байна.

Япон улс: Ерөнхий сайдын дэргэд **Төрийн олон нийтийн аюулгүй байдлыг сахин хамгаалах зөвлөлийг** байгуулан ажилладаг. Тус зөвлөл нь зөвлөлийн дарга ба 5 гишүүнээс бүрдэх ба зөвлөлийн дарга нь Ерөнхий сайд байна. Зөвлөл нь улсын олон нийтийн аюулгүй байдлыг сахин хамгаалах үүрэгтэй Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг удирдаж, цагдаагийн ажилтны сургалт, харилцаа холбоо, мэдээлэл, технологийн дүн шинжилгээ, криминологи, гэмт хэргийн статистик болон цагдаагийн байгууллагын тоног төхөөрөмжинд хяналт тавьж ажиллахаас гадна хувь хүний эрх, эрх чөлөөг хамгаалж олон нийтийн аюулгүй байдал ба хэв журмыг сахиулах үйл ажиллагаанд хяналт тавьдаг болно.

Зөвлөлийн үйл ажиллагааг Цагдаагийн байгууллагын тухай хууль, Япон улсын төрийн аюулгүй байдлыг сахин хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааг явуулах тухай журмаар зохицуулагддаг.

Япон улсын Цагдаагийн байгууллагын тухай хуульд **Орон нутгийн (Засаг захиргааны нэгжийн) олон нийтийн аюулгүй байдлыг сахин хамгаалах зөвлөл** ажилладаг. Засаг захиргааны нэгжүүдийн засаг даргын харьяалалд Орон нутгийн олон нийтийн аюулгүй байдлыг сахин хамгаалах зөвлөл байна. Уг орон нутгийн зөвлөл нь нийслэл, аймгийн болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын тухай хуульд заасны дагуу нэр заагдсан аймагт 5, нэр заасан аймгаас бусад аймагт 3 гишүүнтэйгээр байгуулагдана. Орон нутгийн зөвлөл нь тухайн нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагыг удирдана. Уг орон нутгийн зөвлөл нь Төрийн аюулгүй байдлыг сахин хамгаалах зөвлөл болон бусад Орон нутгийн аюулгүй байдлыг сахин хамгаалах зөвлөлтэй нягт холбоотой ажиллана.

АНУ-ын Луизана муж: Захиргааны байгууллагад гал унтраах болон иргэний цагдаагийн төрөлжсөн үйлчилгээг албан хаагчид, ажилтнуудын албан тушаалыг оролцуулан байгуулдаг ба “гал унтраах болон иргэний цагдаагийн үйлчилгээ” гэж нэрлэнэ. Гал унтраах болон иргэний цагдаагийн үйлчилгээний зөвлөл нь Хотын гал унтраах болон иргэний цагдаагийн үйлчилгээний зөвлөлийг хотын захиргаанд байгуулна. Зөвлөл нь дотроо дарга, дэд дарга, нарийн бичгийн даргын бүрэлдэхүүнтэй байна. Зөвлөл нь орон тооны бус таван гишүүнтэй. Зөвлөл нь үйлчилгээ үзүүлж буй хотдоо байрлах бөгөөд Тухайн хотын нэр дэвшигчийн шаардлага хангасан тухайн хотын оршин суугч, АНУ-ын иргэн Зөвлөлд гишүүнээр томилогдох, нэр дэвших эрхтэй. Зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа таван жил байна.

Оросын Холбооны улс⁴: Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгчийн тушаал 2011 оны 5 дугаар сарын 23-ны “ОХУ-ын Дотоод явдлын яам, харьяа агентлагуудын олон нийтийн зөвлөлийн тухай” 668 дугаар зарлигаар ОХУ-ын төрийн эрх барих албан тушаалтан, эрх бүхий байгууллага, орон нутгийн өөрөө удирдах байгууллага, олон нийтийн байгууллага, хууль сахиулах байгууллагууд, дүүргийн болон бусад байгууллагууд тэр тусмаа мэргэжлийн холбоод, ОХУ-ын дотоод хэргийн шийдвэр гаргах эрх бүхий байгууллагууд, мөн түүнчлэн цагдаагийн байгууллага, иргэдийн олон нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалахын тулд ОХУ-ын Дотоод явдлын яамны дэргэд болон Дотоод явдлын яамны харьяа байгууллага, агентлагуудын дэргэд олон нийтийн зөвлөлийг байгуулжээ.

Олон нийтийн зөвлөл нь шийдвэр гаргах эрх бүхий этгээдэд зөвлөх чиг үүрэг хэрэгжүүлнэ. Олон нийтийн зөвлөл нь дараах үндсэн чиг үүрэгтэй:

- Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага болон холбоодын ашиг сонирхлыг төлөөлж нийгмийн хэв журмыг хамгаалах орчинд улс төрийн оролцоог хангах, профилактики эрхийн зөрчил, олон нийтийн аюулгүй байдлыг хангах мөн түүнчлэн улс төрийн үйл ажиллагааг гэмт явдалтай тэмцэх орчинд хангах,
- Дотоод хэргийн байгууллагууд, олон нийтийн нэгдэл, холбоодын тулгамдсан асуудлууд, иргэний инициатив, концепц, хөтөлбөрүүдийг эргэн харж сайжруулахад гардан оролцох,
- Дотоод хэргийн байгууллагуудын үйл ажиллагааны талаар олон нийтийн анхаарлын төвд байгаа болон бусад асуудлаар иргэд олон нийтэд олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлэл хийхэд оролцох,
- Дотоод хэргийн байгууллагуудын үйл ажиллагааны талаархи иргэдийн санал бодолд задлан шинжилгээ хийж үр дүнгийн талаар дотоод хэргийн байгууллагуудын удирдлагад мэдээлэл хийх,
- Дотоод хэргийн байгууллагуудын үйл ажиллагааны талаархи холбооны хууль, бусад эрхийн актуудын төсөлд дүн шинжилгээ хийх,
- Дотоод хэргийн байгууллагуудын үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх.

Иргэний зөвлөлийн гишүүний сонгон шалгаруулалт, эрх, үүрэг

Аймаг, нийслэлийн Иргэний зөвлөлд 5-7 хүн, улсын хэмжээнд нийт 110-154 хүн Иргэний зөвлөлийн гишүүнээр сонгогдон ажиллах бөгөөд зөвлөлийн гишүүнд Цагдаагийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3, 21.4 дэх хэсэгт заасан шаардлагыг хангасан⁵, иргэн нэр дэвшинэ.

Зөвлөлийн гишүүний сонгон шалгаруулалт:

Аймаг, нийслэлийн ИТХ-аас Ажлын албаны даргаар ахлуулсан сонгон шалгаруулах комисс⁶ байгуулж, дүрэмд зааснаар сонгон шалгаруулна.

Комиссоос ирүүлсэн материалыг аймаг, нийслэлийн ИТХ 7 хоногийн дотор хэлэлцэж,

⁴Албан бус орчуулга болно.

⁵Шаардлага нь:

- Иргэний зөвлөлийн гишүүн нь тухайн нутаг дэвсгэрт сүүлийн 5 жил оршин сууж байгаа, оршин суух бүртгэлтэй, Монгол Улсын иргэнийг аймаг, нийслэлийн ИТХ-аас 3 жилийн хугацаагаар томилно.
- Иргэний зөвлөлийн гишүүн нь сүүлийн 5 жил цагдаа, прокурор, шүүгчээр ажиллаж байгаагүй, ашиг сонирхлын зөрчилгүй Монгол Улсын иргэн байна.

⁶ ИТХ-ын Ажлын албаны хууль зүйн мэргэжилтэн, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ажилтан, Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтсийн дарга, нутаг дэвсгэр болон тодорхой нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дарга, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн төлөөллөөс бүрдсэн комисс

Цагдаагийн албаны тухай хуулийн 21-р зүйл, Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлд заасныг тус тус удирдлага болгон гишүүдийг томилно. Тодруулбал, Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлд “Цагдаагийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасан аймаг, нийслэлийн Иргэний зөвлөлийн 5-7 гишүүнийг анх томилохдоо 5 гишүүнтэй байх бол 1 гишүүн нь нэг жил, 2 гишүүн нь хоёр жил, 2 гишүүн нь гурван жил, 7 гишүүнтэй байх бол 1 гишүүн нь нэг жил, 3 гишүүн нь хоёр жил, 3 гишүүн нь гурван жилийн хугацаатай байхаар тус тус томилно” гэж заасан. Хамгийн олон санал авсанаар эрэмбэлэн жилийг харгалзан томилох нь зүйтэй. Иргэний зөвлөлийн гишүүд үйл ажиллагаа хугацаа нь нэг дор дуусгавар болохоор байгаа тул хуульд заасан хугацаа дуусахад 60 орчим хувь солигдохгүй үлдэж, улмаар тус бодлого, байр суурь нь тогтвортой үргэлжлэхээр зохицуулалт хийсэн.

Зөвлөлийн гишүүнээр томилогдмогц аймаг, нийслэлийн ИТХ, нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагаас зохион байгуулах сургалтад заавал хамрагдана. Уг сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг ЦЕГ-ын даргаар батлуулж, аймаг, нийслэлийн цагдаагийн байгууллагад хүргүүлэх бөгөөд хүргүүлсэн хөтөлбөр, төлөвлөгөөний хүрээнд сургалт явагдана.

Дүрэмд заагдсан үндэслэл тогтоогдсон тохиолдолд зөвлөлөөс ирүүлсэн саналыг үндэслэн аймаг, нийслэлийн ИТХ Зөвлөлийн гишүүнээс чөлөөлнө. Зөвлөлийн гишүүний чөлөөлөгдсөний дараа сул орон тоонд нөхөн томилогдсон гишүүн өмнөх гишүүний бүрэн эрхийн үлдсэн хугацаанд ажиллана. Иргэний зөвлөлийн гишүүнээр ажиллах сонгон шалгаруулалтад тэнцсэн хүмүүсийг нөөцөд бүртгэж, хэрэв гишүүн чөлөөлөгдсөн тохиолдолд нөхөн томилдог байх асуудлыг цаашид авч үзэх. Учир нь цаг хугацаа, хөрөнгө, хүч хэмнэх юм.

Зөвлөлийн дарга, гишүүний эрх, үүрэг:

Зөвлөлийн дарга, гишүүн нь үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомж, энэ дүрмийг мөрдөж ажиллана.

Зөвлөлийн дарга, гишүүд нь Цагдаагийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6-д заасан бүрэн эрхийн хүрээнд үйл ажиллагаа явуулна.

Зөвлөлийн дарга, гишүүн нь Цагдаагийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан:

- цагдаагийн байгууллагын мөрдөн шалгах үйл ажиллагаанд аливаа хэлбэрээр оролцох;
 - улс төрийн үйл ажиллагаа явуулахыг хориглосон.
- Англи улсад иргэний зөвлөл нь хэтэрхий улс төржсөний улмаас татан буулгах асуудал хурцаар тавигдсан гашуун туршлага байдаг.

Иргэний зөвлөлийн үйл ажиллагааны хэлбэр:

Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь ээлжит болон ээлжит бус хуралдаан байна. Зөвлөлийн ээлжит хуралдааныг улиралд 1-ээс доошгүй удаа зохион байгуулна.

Зөвлөл нь тухайн жилийн 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор дараа жилийн ээлжит хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөө боловсруулан, баталж, цахим хуудсанд байршуулна. Тухайн НИТХ-ын цахим хуудас, цахим хуудасгүй бол Засаг даргын Тамгын газрын цахим сайтаар дамжуулна.

Цагдаагийн төв байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн ИТХ, нутаг дэвсгэр болон тодорхой нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дарга Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлаар санал ирүүлж болно.

Зөвлөлийн дарга нь ээлжит хуралдаан болохоос 3 хоног, ээлжит бус хуралдаан болохоос 1 хоногийн өмнө хуралдааны хөтөлбөр, хэлэлцэх асуудлын талаарх мэдээлэл, танилцуулгыг Зөвлөлийн гишүүдэд хүргүүлж, гишүүд хуралдаан болохоос өмнө мэдээлэлтэй танилцах арга хэмжээ авна.

- Канадын туршлага бол хэлэлцэх асуудлыг урьдчилан танилцсан байх талаар

оруулсан байдаг.

Зөвлөлийн даргын баталсан ДЭГИЙН дагуу Зөвлөлийн хуралдааныг явуулна.

- Дэгийн талаар олон улсын өргөн туршлага бас байдаг. Зөвхөн дэг гэдэг байдлаар оруулсан болно.
- Хуралдаанаархэлэлцсэн асуудал, хөтөлбөр, холбогдох мэдээллийг хуралдаан болсноос хойш ажлын 3 өдөрт багтаан цахим хуудсанд байршуулна.

Зөвлөл хагас жилд хийж гүйцэтгэсэн ажлын тайлангаа 7 дугаар сарын 10-ны өдрийн дотор, бүтэн жилд хийж гүйцэтгэсэн ажлын тайлангаа дараа оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор цахим хуудас, хэвлэл, мэдээллийн хэрэгсэл болон бусад хэлбэрээр олон нийтэд хүртээмжтэй мэдээлнэ.

Зөвлөлийн гишүүнд олгосон урамшил, хуралдаанд оролцсон ирцийн мэдээллийг дараа жилийн 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор цахим хуудсанд байршуулж нийтэд мэдээлнэ.

Зөвлөл нь үйл ажиллагааны явц, үр дүн, хийсэн ажлын талаар аймаг, нийслэл, нийслэлийн ИТХ-ын даргад танилцуулж, нийтэд мэдээлнэ.

Иргэний зөвлөлийн үйл ажиллагааны өнөөгийн байдалд хийсэн дүн шинжилгээ

№	Аймгийн нэр	Нэр дэвшигч	Гишүүд	Тайлбар
1.	Баян-Өлгий	10	7	Радиоогоор зарлаж, ЗДТГ-ын цахим хуудас болон олон нийтийн зарын самбарт зар гаргасан. Сонгон шалгаруулалтыг зөвхөн цахим хуудсаар хийсэн. ИЗ-ийн гишүүдийг ялгаатай хугацаагаар томилоогүй. Өөрөө гаргаж өгсөн ч цахилгаангүй.
2.	Булган	12	5	Сумдад хүргүүлж, ирсэн саналыг үндэслэн ИЗ-ийн гишүүдийг томилсон. Иргэний танхимд ажилладаг. Гишүүдийг хуулийн дагуу ялгаатай хугацаагаар томилсон.
3.	Дархан-Уул	16	5	ЛХА, DBS ТВ, сум багаар дамжуулан зарлаж, санал авах замаар ИЗ-ийн гишүүдийг томилсон. ИЗ-ийн гишүүдийг ялгаатай хугацаагаар томилоогүй. Ажлын өрөөгүй.
4.	Завхан	16	5	Цахимаар, ИТХ-ын ил тод байдлын самбар, орон нутгийн ТВ-ээр зар тараасан. Гишүүдийг хуулийн дагуу ялгаатай хугацаагаар томилсон. Ажлын өрөөгүй, иргэний танхимд хуралддаг.
5.	Сэлэнгэ	14	5	Мэдээллийн самбар, бусад хэлбэрээр мэдээлэл тарааж, бүх сумын багийн ИНХ, ИТХ ¹ нэр дэвшигч бүрээр хэлэлцүүлж, санал авах замаар ИЗ-ийн гишүүдийг томилсон. Иргэний зөвлөл ИТХ-ын ажлын албаны дэргэд тусдаа өрөөтэй. ИЗ-ийн гишүүдийг хуулийн дагуу ялгаатай хугацаагаар томилсон. Иргэний зөвлөл нь үйл ажиллагааны төсөв байхгүй.
6.	Орхон	18	5	Эрдэнэт, номин, Лха, ТВ10 телевиз, FM 107.1 радио, www.erdenet.mn, www.ITH-orhon.mn , Жаргалант сумдын ИТХ, багуудын ИНХ-д албан тоотоор хүргүүлж санал авах замаар ИЗ-ийн гишүүдийг томилсон. Гишүүдийг хуулийн дагуу ялгаатай хугацаагаар томилсон. Ажлын өрөө гаргасан ч засвар хийх шаардлагатай.
7.	Увс	9	7	САМС, МВС ТВ, ИТХ-ын цахим хуудсанд зар тавьж, сумдын ИТХ-д албан тоот хүргүүлж, санал авах замаар ИЗ-ийн гишүүдийг томилсон. ИЗ-ийн гишүүдийг ялгаатай хугацаагаар томилоогүй. ИЗ нь тогтмол ажлын өрөө байхгүй, хуралдах үед нь ЗДТГ-ын хурлын танхимаас

				гаргаж өгдөг.
8.	Улаанбаатар	14	7	UBS.MN, C1 tv, Өдрийн сонин, Монголын нэг өдөр сонин, www.ulaanbaatar.mn , www.citycouncil.mnсайтаар олон нийтэд зар хүргэж, цахимаар санал авч ИЗ-ийн гишүүдийг томилсон. Нийслэлийн цагдаагийн газарт ажлын өрөө гаргаж өгсөн. ИЗ-ийн гишүүдийг хуулийн дагуу ялгаатай хугацаагаар томилсон.
9.	Ховд	9	5	ИЗ-ийн гишүүдийг ялгаатай хугацаагаар томилоогүй, Ажлын өрөөгүй.
10.	Хөвсгөл	6	5	Цагдаагийн газарт ажлын өрөөтэй.

Иргэний зөвлөлийн үйл ажиллагааны санхүүжилт:

Дүрмийн 7.1-д “Зөвлөлийн төсөв, гишүүдийн урамшлыг Цагдаагийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.9-д заасны дагуу тухайн аймаг, нийслэлийн төсвөөс санхүүжүүлнэ.” гэж заасан. Тухайн ИТХ-аар асуудлыг танилцуулж, шийдвэрлүүлнэ.

- Зөвлөлийн гишүүний урамшлыг сайтар судалж, НИТХ-д оруулж батлуулах. Гадаад улс оронд 1 хуралдаанд суухад 100\$ гэх мэт янз бүрийн байдлаар урамшлыг зохицуулдаг.

Урамшуулал олгож буй байдал 2014-2016 оны эхэн хүртэл

№	Аймгийн нэр	Иргэний зөвлөл	ОНЦА	Санхүүжилтийн эх үүсвэр
1.	Баян-Өлгий	Зөвхөн нарийн бичгийн даргад 200000 төгрөг өгч байсан ч 2015 оны 10 сараас энэ урамшуулал зогссон	192.000	8 сум ОНЦА ажиллуулахаар томилсон ч Сагсай, Цэнгэл сумын ОНЦА л урамшуулал авч байгаа бөгөөд сумын төсвийн давсан орлогоос санхүүжүүлсэн. ИЗ-ийн төсвийг ГХУСА33-ийн төсвөөс олгосон.
2.	Булган	ХХОАТ, НДШ-ийг 200000 төгрөгөөс хасаж, гарт олгоно.	250.000-350.000	ИЗ-ийн гишүүдийн урамшууллыг ГХУСА33-өөс ОНЦА-ыг сумын ИТХ-ын давсан орлогоос
3.	Дархан-Уул	2014 оны сүүлийн 2 сар, 2015 онд 192000 төгрөг олгосон.	192.000	ОНЦА-ы урамшуулалд ГХУСА33-ийн төсвийн 80%-ийг зарцуулдаг тул өөр зорилгод зарцуулах төсөвгүй болдог. ИЗ-ийн урамшууллыг ЗДТГ өгдөг.
4.	Завхан	ИЗ-ийн гишүүнд 2014 онд 30000 төгрөгийн урамшуулал өгч байгаад 2015 оноос 50000 төгрөгөөр тогтоосон.	192.000	ОНЦА-ы урамшууллыг 2015 оны 5 сараас олгохыг зогсоож, чөлөөлсөн ИЗ-ийн урамшууллыг аймгийн ЗД-ын нөөц сангаас, ОНЦА-ны урамшууллыг Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэхээр сумдын засаг дарга нартай тохирсон ч хууль зөрчсөн тул хэрэгжүүлээгүй.
5.	Сэлэнгэ	ИЗ дарга 210000, нарийн бичгийн дарга 190000, гишүүд 180000	300.000	Иргэний зөвлөл болон ОНЦА-ы урамшууллыг ГХУСА33-ийн төсвөөс олгосон.
6.	Орхон	2015 оны 5-р сараас 200000	350.000	ОНЦА-ы сургалтын зардал 1.900.000 төгрөгийг ИТХ-ын дэргэдэх ГХУСА33 зардлаас, бусад зардал болох урамшуулал, хувцас хэрэглэлийн зардлыг орон нутгийн төсвөөс гаргасан. ИЗ-ийн төсөв ИТХ-аас өгч байгаа. Үйл ажиллагааны зардлыг ИТХ-ын зардалд тусгасан. Сангийн яам

				мөнгөө татсан тул үйл ажиллагааны зардал ИЗ-д олгогдоогүй.
7.	Увс	2014 онд урамшуулал олгоогүй. 2015 оны 2,3-р улиралд ирцийг харгалзан сард 15000 олгосон.	Төсөв байхгүй.	ИЗ-ийн төсвийг ГХУСА33-ийн төсвөөс олгосон.
8.	Улаанбаатар	375000	439.239	ИЗ, ОНЦА-ны урамшууллыг нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн төсвөөс санхүүжүүлдэг.
9.	Ховд	Урамшуулалгүй	100.000	ИТХ-ын төсвөөс ОНЦА-ы урамшууллыг өгч байна.
10.	Хөвсгөл	Урамшуулалгүй	192.000	Их-Уул, Тосонцэнгэл сум Засаг даргын тамгын газрын давсан орлогоос алдаг оног олгодог. 2016 онд урамшуулал олгох ансуудал хүндрэлтэй байна.

Дээрх дурдагдсан 10 аймагт иргэний зөвлөлийн үйл ажиллагааг дэмжин төсөв санхүү, шаардлагатай хэрэгсэлээр хангаж, үйл ажиллагааг тогтмол хэвийн болгох шаардлагатай байна.

Иргэний зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн чиглэл

Иргэний зөвлөл хараат бус ажиллаж, тухайн нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих үүрэгтэй. Зөвлөл нь Цагдаагийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6 дахь хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

1. Цагдаагийн байгууллагын төсвийн төсөл, зарцуулалт, үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг сонсох;
2. Цагдаагийн алба хаагчийн сургалт, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх үйл ажиллагаанд шинжлэх ухааны ололт, орчин үеийн техник, технологи, мэдээллийн сүлжээг нэвтрүүлэх бодлогын хэрэгжилтэд хяналт тавих;
3. Цагдаагийн байгууллагын гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл хүлээн авах, бүртгэх ажилд хяналт тавих, тэдгээртэй холбоотой мэдээлэлд дүн шинжилгээ хийх;
4. Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх;
5. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Засаг даргын хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал боловсруулах.

Иргэний зөвлөл бүрэн эрхийнхээ хүрээнд ИТХ болон цагдаагийн төв байгууллагын дарга, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд тус тус санал, зөвлөмжөө хүргүүлнэ. ЦБ-ын үйл ажиллагаа, эрх зүйн орчин, цагдаагийн байгууллага, алба хаагчдын нийгэм, эдийн засгийн баталгааг сайжруулах талаар болон бусад асуудлаар санал, зөвлөмжөө хүргүүлж болно.

Цагдаагийн албаны тухай хуульд заасан дээрх бүрэн эрхийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дүрэмд нарийвчлан зохицуулсан. Дэмжлэг үзүүлэх үүргийг хэрэгжүүлэх хүрээнд:

в/цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд иргэд, төрийн бус байгууллагын түншлэл, итгэлцлийг сайжруулах, гадаад орны ижил төрлийн байгууллагатай хамтын ажиллагаа тогтоож, туршлага судалж, хэрэгжүүлэх;

- Гадаад орны туршлагыг эхний ээлжинд судлах зайлшгүй шаардлагатай.
 - Иргэд, төрийн бус байгууллагын түншлэл, итгэлцлийг сайжруулахад анхаарах.
- д/гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй мэдээлэл

солилцож, хамтран ажиллах;

- Иргэний зөвлөлийн дарга Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбарын зөвлөлийн гишүүнээр оролцож, асуудлаа танилцуулах боломжийн нээх хэрэгтэй болно.

Иргэний зөвлөл болон цагдаагийн хамтын ажиллагаа

Дүрэмд Цагдаагийн байгууллага нь Зөвлөлтэй хамтран ажиллах талаар эдлэх эрх, хүлээх үүргийг дүрмийн 8 дугаар зүйлд тусгасан. Үүнд:

- Зөвлөлийн хуралдаанд оруулах санал, холбогдох мэдээлэл, танилцуулгыг хуралдаан болохоос ажлын 3 хоногийн өмнө Зөвлөлд хүргэнэ;
- Зөвлөлийн хуралдаанаас гарсан, хууль тогтоомжид нийцсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, хэрэгжүүлэх боломжгүй тохиолдолд шалтгаан, үндэслэл бүхий хариу өгнө;
- Зөвлөлийн үйл ажиллагаанд шаардлагатай туслалцаа, дэмжлэг үзүүлж, хууль тогтоомжид заасан эрх, үүргийн дагуу хамтран ажиллана;
- Зөвлөлийг шаардлагатай мэдээ, мэдээллээр хангаж ажиллана;
- Зөвлөлтэй хамтран ажиллах асуудал хариуцсан алба хаагчийг Цагдаагийн ерөнхий газар, нутаг дэвсгэр, тодорхой нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад ажиллуулж, түүний ажлын байрны тодорхойлолтод үүргийг нь нэмж тусгана.
- Тухайн цагдаагийн байгууллагын даргын зөвлөлийн гишүүн, зөвлөлтэй хамтран ажиллах асуудал хариуцсан цагдаагийн алба хаагч нь Зөвлөлийн хүсэлтээр хуралдаанд оролцож, тус байгууллагын бодлого, үйл ажиллагааны талаар тайлбар, хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудалд санал өгнө;

Иргэний зөвлөлд Цагдаагийн байгууллагаас тайлан тавих зохицуулалт

Цагдаагийн албаны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.2-д “цагдаагийн төв байгууллага болон харьяалах Иргэний зөвлөл, оршин суугчид ажлаа тайлагнах”; мөн хуулийн 14.2-д “Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дарга нь үйл ажиллагааныхаа тайланг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, оршин суугчдад, түүнчлэн тодорхой нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага, алба хаагч нь үйл ажиллагааныхаа тайланг тухайн нутаг дэвсгэрийн иргэдэд тавина” гэж заасан.

Цагдаагийн албаны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.8-д “Энэ хуулийн 14.1-д заасны дагуу Иргэний зөвлөл, оршин суугчдад цагдаагийн байгууллагын тайлан тавих журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж заасны дагуу ХЗСайдын 2014 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн А/89 дүгээр тушаалаар “Иргэний зөвлөл, оршин суугчдад цагдаагийн байгууллагын тайлан тавих журам” баталсан.

Уг журамд зааснаар нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага харьяалах Иргэний зөвлөл болон оршин суугчдад хагас жилийн тайланг 7 дугаар сарын 10-ны дотор, бүтэн жилийн тайланг дараа оны 1 дүгээр сарын 15-ны дотор; тодорхой нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага, алба хаагч нь тухайн нутаг дэвсгэрийн иргэдэд жил бүрийн 1 дүгээр сарын 15-ны дотор цагдаагийн байгууллага, алба хаагч нь үйл ажиллагааныхаа тайланг тавина.

Харин нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дарга харьяалах Иргэний зөвлөлд хагас, бүтэн жилээр үйл ажиллагааны тайланг хүргүүлэх юм. Цагдаагийн ерөнхий газрын дарга, Иргэний зөвлөл нь шаардлагатай тохиолдолд нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын тайланг авч болно. Ажилүүргийн зарчмаар байгуулагддаг цагдаагийн байгууллага, алба хаагч нь нутаг дэвсгэрийн Иргэний зөвлөл, оршин суугчдад тайлан тавьж болох юм.

ДҮГНЭЛТ

Цагдаагийн байгууллагын эрх зүйн шинэчлэлийн талаар дурьдаж, хууль, дүрмийн зохицуулалтын хүрээнд Иргэний зөвлөлийн үйл ажиллагааг хэрхэн төлөвлөн хэрэгжүүлэх, анхаарах зарим асуудлыг томъёолов. Улмаар туссан санал, дүгнэлт Иргэний зөвлөлийн үйл ажиллагааг төгөлдөржүүлэхэд зохих хувь нэмэр болох болов уу гэж үзэж байна. Цаашид Иргэний зөвлөл ажилласнаар гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах ажилд тодорхой ахиц дэвшил гарч, хүний эрх, эрх чөлөө хамгаалагдах, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах бодлого боловсруулах, хэрэгжүүлэх ажлын чанар, хамтын ажиллагаа сайжрах, нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих эрх зүйн орчин бүрдэх, цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа ил тод, олон нийтэд нээлттэй болох; цагдаагийн байгууллагад өгөх иргэдийн үнэлгээ өсч, тэднийг үл хүндэтгэсэн хандлага багасах; цагдаагийн албан хаагчийн ёс зүй дээшлэх, салбар дахь авлига буурах ач холбогдолтой.

САНАЛ

Энэхүү өгүүллээр дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Цагдаагийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, үйл ажиллагааны талаарх мэдээллийг Иргэний зөвлөлийн гишүүдэд мэдээлэх, танилцуулах, таниулах сургалтыг үе шаттайгаар зохион байгуулж байх;

2. Цагдаагийн албаны тухай хууль, Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль, Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр, түүнийг баталсан үзэл баримтлалыг Иргэний зөвлөлийн гишүүдэд тайлбарлан таниулах, ойлгуулах; Иргэний зөвлөлийн гишүүд өөрсдөө хууль, ялангуяа ажиллах Дүрмийн зохицуулалтыг сайтар судлах нь зүйтэй. Үүнд үндэслэн хийх ажлын чиглэлээ өөрсдөө оновчтой тодорхойлох боломжтой.

3. Аймаг, нийслэл дүүрэг, зарим төрийн байгууллагын дэргэд Иргэний зөвлөл, Олон нийтийн зэрэг орон тооны бус зөвлөлүүд үйл ажиллагаа явуулж байна. Иймд жишээ нь: “Улаанбаатар хотын цагдаагийн газрын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих НИТХ-ын дэргэдэх Иргэний зөвлөл” хэмээн нэршиж хэвших; Иргэний зөвлөлийн шийдвэр, зөвлөмж, саналыг албажуулахын тулд НИТХ-ын албан бланкыг ашиглаж, тамгыг дарж баталгаажуулах нь зүйтэй.

4. Иргэний зөвлөлийн үйл ажиллагааг өдөр тутмын ажил, хуралдааны бэлтгэл, тэмдэглэл хөтлөх зэрэг ажлыг НИТХ-ын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ажилтнаар гүйцэтгүүлэхэд санаачлага гаргах ажиллах;

5. Хууль, дүрэм, журмаар Иргэний зөвлөлийн гишүүд олон бүрэн эрх, эрх, үүрэгтэй байгаа учраас хийх ажлын чиглэл, дарааллаа тодорхойлох, Иргэний зөвлөл жилийн хугацаанд хийх ажлын төлөвлөгөө гарган, баталж хэрэгжүүлэх; *(Дүрмийн 4.3 дах заалт: тухайн жилийн 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор дараа жилийн ээлжит хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөө боловсруулан, баталж, цахим хуудсанд байршуулна)*

6. Япон, Англи, Канад гэх улс оронд цагдаагийн үйл ажиллагаанд хяналт тавих зөвлөл нь харилцан адилгүй түвшинд байгуулагдаж, үйл ажиллагаа явуулдаг. Тэдний гишүүдийн цалин, урамшил нь харилцан адилгүй олгогддог. Манай иргэний зөвлөлийн гишүүд олон төрлийн ажил гүйцэтгэхээр байгаа, иймд Иргэний зөвлөлийн гишүүний урамшлыг сайтар судалж, ИТХ-аар оруулж батлуулах;

7. Цагдаагийн албаны тухай хуулийн 21.1-д “нутаг дэвсгэр хариуцсан5-7 иргэний төлөөллөөс бүрдсэн орон тооны бус Иргэний зөвлөл аймаг, нийслэлийн ИТХ-ын дэргэд байна” гэж заасан. Учир нь Монгол Улсын 2.9 сая орчим хүний бараг 60 орчим хувь нь амьдардаг, ажилладаг, сурдаг Улаанбаатар хотын цагдаагийн газрын үйл ажиллагаа аль нэг аймгийн цагдаагийн газрын үйл ажиллагаатай харьцуулалшгүй их ачаалалтай, үйл

ажиллагааны цар хүрээ өргөн юм. Иймд нийслэл, түүнчлэн дүүргийн цагдаагийн газрын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих үүрэг бүхий Иргэний зөвлөлийг бий болгох асуудлыг тавьж, холбогдох хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, ХЗСайдад зөвлөмж хүргүүлэх эрх зүйн зохицуулалт дүрэмд бий. Дүүргүүдийн иргэний зөвлөлийн дарга нар нийслэлийн хэмжээний Иргэний зөвлөлөө бүрдүүлдэг байх зохицуулалт зайлшгүй үгүйлэгдэнэ.

8.Иргэний зөвлөл орон тооны бус, байнгын тогтвортой бус ажиллах учраас өөрсдийн ачааллыг нэмэгдүүлэхгүй байх асуудлыг эртнээс бодолцож үзэх нь зөв. Иргэдээс өргөдөл, гомдол, мэдээлэл, санал хүсэлтийг авахгүй байхад онцгой анхаарах. Харин тэдний зүгээс цагдаагийн байгууллагад шүүмжлэлтэй хандаж буй мэдээлэл, үзэл бодлын мөрөөр өөрсдөө хяналт тавьж ажиллахад анхаарах;

9.Иргэний зөвлөл хяналт тавихаас гадна дэмжлэг үзүүлэх үүрэгтэй. Иймд Улаанбаатар хотын цагдаагийн газрын үйл ажиллагаа, хотын иргэдийн аюулгүй, амгалан амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, цагдаагийн алба хаагчдын нийгэм, эдийн засгийн баталгааг хангах, сайжруулах чиглэлээр тодорхой ажил санаачлан хэрэгжүүлэх;

10.Япон, Канад, Англи, ОХУ зэрэг улс орны ЦБ-ын үйл ажиллагаанд хяналт тавьж, дэмжлэг үзүүлж буй орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагааг гадаад оронд нь очиж туршлага судалж, нутагшуулах;

11.Иргэний зөвлөлийн хэрэгжүүлэх үйл ажиллагаанд судалгаа хийх, дүн шинжилгээ хийх ажлуудыг судалгааны байгууллага, их, дээд сургууль, төрийн бус байгууллагаар захиалга, гэрээгээр гүйцэтгүүлж, хамтран ажиллахад анхаарах;Цагдаагийн байгууллага, газар, нэгж бүр дээр Иргэний зөвлөлийн санал авах хайрцаг (битүүмжилж лацдсан) байрлуулж, иргэдийн санал хүсэлтэд дүн шинжилгээ хийж ажиллах, *(өргөдөл, гомдол, хүлээн авахгүй, харин процесст нь хяналт тавина гэдгээ ойлгуулах)*

12.Иргэний зөвлөлийн хийх ажлын чиглэлийг холбогдох төрийн байгууллагаас мэдээлэл, танилцуулгыг гаргуулан авах, түүнд дүн шинжилгээ хийх байдлаар ажлын зохицуулалт хийх, зөвлөл дээрээ ачаалал авахыг багасгахад анхаарах; Иргэдийн төлөөлөгчдийн хурал, харьяалах цагдаагийн газрын цахим хуудсанд “Иргэний зөвлөл” булан нээж, түүгээр дамжуулан үйл ажиллагаагаа цагдаагийн алба хаагчдад төдийгүй олон нийтэд сурталчлах, шинээр байгуулагдаж буй учраас “Олон нийтэд таниулах маркетинг” хийх,

- Зөвлөлийн дүрэм, журам

- Иргэний зөвлөлийн гишүүдийн зураг, товч намтар

- Аймаг орон нутаг, нийслэлд буй иргэний зөвлөлийн вэб сайтыг ажиллуулан тогтмол мэдээлэл оруулах

Иргэний зөвлөлийн санал, зөвлөмж, шийдвэрт холбогдох байгууллага, албан тушаалтанд заавал хариу өгдөг байх, түүний дагуу хийсэн ажлын мэдээлэл, үр дүнг нэхдэг шаарддаг эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан тусгаж өгөх.

Ашигласан ном зүй

Хóóëü, ðîãðîïïæ

1. Ìïïãîë Öëñûí Òãñýí ðóóëü;
2. Цагдаагийн албаны тухай хууль;
3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль;
4. Цагдаагийн албаны тухай хууль;
5. Цагдаагийн албан тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль;
6. Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр;
7. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль;

8. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө⁷;
9. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал;
10. Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө;

Судалгааны материал

11. УИХ-ын Хууль зүйн байнгын хороо, ХБНГУ-ын Хансс Зайделын сан, ХСИС-ийн хамтран 2013 онд зохион байгуулсан “Гэмт хэрэгтэй тэмцэх төрийн бодлогын хэрэгжилт” олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл;
12. “Хууль сахиулахуй” онол, арга зүйн сэтгүүл, 2014 оны №01;
13. “Хууль сахиулахуй” онол, арга зүйн сэтгүүл, 2014 оны №02;
14. ХСИС-ийн Цагдаа судлалын төвийн 2013 оны Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаар хийсэн судалгааны тайлангууд, Эмхэтгэл-1, Эмхэтгэл-2, 2014 он;

Цахим хуудас

15. Монгол Улсын Ерөнхийлөгч, <http://www.president.mn/mongolian>;
16. Монгол Улсын Их Хурал, <http://www.parliament.mn>;
17. Монгол Улсын Засгийн газар, <http://zasag.mn>;
18. Хууль зүйн яам, <http://moj.gov.mn>;
19. Авлигатай тэмцэх газар, www.iaac.mn;
20. Цагдаагийн ерөнхий газар, <http://police.gov.mn>;
21. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, <http://www.legalinfo.mn>;
22. Улаанбаатар хотын Засаг даргын Тамгын газар, <http://ulaanbaatar.mn>;
23. Хууль сахиулахын их сургууль, <http://leu.gov.mn>;
24. Нээлттэй нийгэм форум, <http://forum.mn>;

Хянасан: Цагдаагийн хурандаа Ю.Бадамханд

⁷Засгийн газрын 2012 оны 252 дугаар тогтоолоор баталсан.